

тэн, судлаачид, БНСУ дахь монгол судлаачид, оюутан, зарим корпораци, үйлдвэр худалдааны газрын төлөөлөгчид оролцов. Хурлыг Соганы Их сургуулийн проректор, Монголын ШУА-ийн ДДОУС-ын хүрээлэнгийн захирал, дэд доктор Ц. Батбаяр нар нээж Монгол Улсаас БНСУ-д суугаа онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд П. Үржинлхүндэв, тус хурлыг ивээн тэтгэсэн Жинро нэгтгэлийн захиралуудын зөвлөлийн дарга С. М. Карл нар баяр хүргэж үг хэлэв.

Энэ хурлыг ивээн тэтгэсэн Жинро болон тус нэгтгэлийн захиралуудын зөвлөлийн дарга, ноён С. М. Карлд хуралд оролцогчид талархал илэрхийлэв.

Хурлын үеэр хоёр хүрээлэнгийн хамтын ажиллагааны асуудлаар санал солилцож ээлжит III хурлыг 1995 онд Улаанбаатар хотноо хийхээр тогтов.

ОЛОН УЛСЫН ЭРДЭМТДИЙН ЯРИЛЦЛАГА ЗОХИОН ЯВУУЛАВ

Ж. Гантулга

1993 оны 8-р сарын 18-20-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо ШУА-ийн Дорно дахин, олон улс судлалын хүрээлэнгээс эрхлэн Япон улсын Энх тайвныг хамгаалах «Сасакава» сантай хамтран «Зүүн хойт Азийн эдийн засгийн хамтын ажиллагаа» сэдэвт эрдэмтдийн хамтарсан төслийн талаар ярилцлага зохион явуулав. Энэ ярилцлагад Монгол, ОХУ, Өмнөт Солонгос, БНХАУ, Япон зэрэг орны эрдэмтэд оролцож, тус бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны өнөөгийн түвшин, хэтийн төлөвийн талаар сонирхолтой илтгэл тавьж хэлэлцүүлэн тухайн асуудлаар саналаа солилцов.

Ярилцлагад оролцогч орнуудын эдийн засгийн өнөөгийн байдал, бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаанд оролцох боломж, чадавхийн талаар орон тус бүрээс хоёр илтгэл тавьсан Монголын талаас Дорнодахин, олон улс судлалын хүрээлэнгийн дэд захирал, доктор, профессор Х. Дашдондов, «Зүүн хойд Азийн орнуудын хамтын ажиллагаа-Монгол», Эдийн засгийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, дэд доктор С. Лхагваа «Монгол улсын эдийн засгийн өнөөгийн байдал» гэсэн илтгэлүүдийг төлөөлөгчид ихэд сонирхон илтгэлтэй холбогдуулан асуулт тавьж байв.

Мөн ярилцлагад Японы эрдэмтэн, доктор, профессор Тан Хашидагийн тавьсан «Зүүн хойт Азийн хамтын ажиллагааны санхүүжилт, Японы оролцоо» илтгэл нь нилээд дэлгэрэнгүй сонирхолтой болов.

Энэ арга хэмжээнд ОХУ-аас доктор Н. Михеева, В. Сыркин нар, Өмнөт Солонгосоос эрдэмтэн Ли Ван Чул, Сун Байк Нам, Японоос доктор, профессор Тан Хашида, доктор Хишида зэрэг эрдэмтэн, мэргэжилтнүүд оролцсон бөгөөд тус уулзалт нь Зүүн хойт Азийн эдийн засгийн хамтын ажиллагааны томоохон төслийн нэг хэсэг болж, улмаар тухайн бүс нутгийг бүхэлд нь хамарсан хамтын ажиллагааны олон улсын нийгэмлэг, механизмыг бий болгох нь ярилцлагад оролцогчдийн гол зорилго байлаа.